



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 01 өдөр

Дугаар 8/113

Хэрлэн сум

Тусгай зөвшөөрөл сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 12.13 дахь хэсэг, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт, архидан согтууруулахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.7, 40 дүгээр зүйлийн 40.7 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан “Согтууруулах, ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох, хяналт тавих журам”-ыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Дараах аж ахуйн нэгжүүдийн согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг 2023 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 3-н сайдын тушаалаар тусгай зөвшөөрлийн тоог батлах хүртэлх хугацаагаар сунгасугай.

Хүнсний дэлгүүр:

- |                      |                       |
|----------------------|-----------------------|
| 1. Хэрлэн сум        | ЖОНШТ ХХК             |
| 2. Хэрлэн сум        | Золбоот Хэрлэн ХХК    |
| 3. Хэрлэн сум        | Сариг гол ХХК         |
| 4. Хэрлэн сум        | Дэвжих тамир ХХК      |
| 5. Хэрлэн сум        | Өсөх будаа ХХК        |
| 6. Хэрлэн сум        | Ерөн Ес Хоршоо ХХК    |
| 7. Мөрөн сум         | Түмэн Богц ХХК        |
| 8. Батноров сум      | Ундрах өсөх ХХК       |
| 9. Цэнхэрмандал сум  | Оргилуун баян зам ХХК |
| 10. Цэнхэрмандал сум | Цэлмэг цэнхэр ХХК     |
| 11. Батноров сум     | Зосын овоо ХХК        |
| 12. Дадал сум        | Гэгээн итгэл ХХК      |

2.

Баар:

- |                     |                  |
|---------------------|------------------|
| 1. Хэрлэн сум       | Цэнэ Трейд ХХК   |
| 2. Цэнхэрмандал сум | Гансоёмбо ХХК    |
| 3. Батширээт сум    | Жаргал билэг ХХК |

Зоогийн газар, ресторан

- |               |                      |
|---------------|----------------------|
| 1. Хэрлэн сум | Хааны алтан ураг ХХК |
|---------------|----------------------|

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг согтууруулах ундааны үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ эрхлэхэд хяналт тавих аймгийн Комиссын дарга (Л.Батсайхан), Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Д.Батхүү), Татварын хэлтэс (А.Гантөмөр), холбогдох сумдын Засаг дарга наарт үүрэг болгосугай.

3. Энэхүү захиргааны актыг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд албан ёсоор гардаж авснаас хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх эрх бүхий байгууллагад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ

